НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛ, ТАТВАР, САНХҮҮГИЙН ХЯНАЛТ
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ИТГЭМЖЛЭГДСЭН ХОНДЛОНГИЙН БАЙГУУЛЛАГА

IJAH AUDIT

# "Ай Жэй Эй Эйч-Аудит" ХХК

2019 оны 01 сар 31 өдөр    № 12    Улаанбаатар хот

"ЖУУЛЧИН ГОВЬ" ХК-ний захирал Б.Гантулга танаа

## Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

"ЖУУЛЧИН ГОВЬ " ХК-ний 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын тайлан,тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан,өмчийн өөрчлөлтийн тайлан,мөөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээрэдгээр санхүүгийн тайлангууд ньбүх материаллаг зүйлсийн хувьд "ЖУУЛЧИН ГОВЬ" ХК-ний 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан,тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн санхүүгийн тайлан,үйл ажиллагааны үр дүн,өмчийн тайлан,мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын олон улсын стандартад зохицуулан үнэн зөв толилуулсан байна.

**Аудитын дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэв.Эдгээр стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэ тайлангийн санхүүгийн тайлангийн аудиторын хүлээх хариуцлага гэсэн хэсэгт харууллаа.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай бөгөөд зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна

**Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шүүмжээр аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант үеийн санхүүгийн иайланд хамгийн их нөлөөтэй болно.Санхүүгийн иайлангийн аудитын хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба тусдаа дүгнэлт гаргаагүй болно

**Санхүүгийн тайлангийн талаарх компаний удирдлагын хариуцлага:**

Санхүүгийн тайланг санхүүгийн тайлагналын олон улсынстандартын дагуу бэлтгэж үнэн зөв толилуулах нь удирдлагын хариуцлага.Алив алдаанаас үүсэн материаалаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж үнэн зөв гаргахтай холбогдсон дотоод хяналтыг хэрэгжүүлэх,нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогыг сонгож хэрэглэх зэрэгт энэхүү хариуцлага хамаарна.Санхүүгийн тайланг гаргахдаа удирдлага компаний тасралтгүй явуулах хариуцлагаа хүлээнэ.

**Санхүүгийн тайлангийн талаарх аудиторынхаруцлага**

Аудиторын үүрэг бол гүйцэтгэсэнаудитынажилдаа тулгуурлан санхүүгийн тайланд дүгнэлт гаргах явдал.Аудитын дүгнэлтээ бид аудитын олон улсын стандартын дагуу хийж гүйцэтгэн,дүгнэлтээ гаргах явдал.

Аудитын үед санхүүгийн тайлан дахь дүн мэдээ болон тодруулгын тала

ар аудитын нотолгоо олж авахад чиглэсэн горимыг баримтлана.Ингэхдээ элдэв буруу байж болох эрсдлээс сэргийлэхэд анхаарах нь зүйн хэрэг.Энд мөн тухайн байгууллагын дотоод хяналтын ач холбогдлыг анхаарах нь зүйн хэрэг

Мөн нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх,олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах боломж,материаалаг бус байдал байгаа эсхийг тодорхойлно

**Тайлангийн хэрэглээ**

Бид энэхүү аудитын дүгнэлтээ **"ЖУУЛЧИН ГОВЬ"**

ХК –ний эзэмшигчид зориулж бэлтсэн.Тайлангийн агууллагын хүрээнд өөр алив нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

**АЙ ЖЕЙ ЭЙ ЭЙЧ аудит компани.**

**Тайлангийн дүгнэлт үйлдсэн аудитор.................**

**. 2019-01-31-ны өдөр**

| | | |
|---|---|---|
| Компанийн нэр /Оюосон нэр/ | Монгол | "Жуулчин говь" ХК |
| Компаний удирдлага | Б.Гантулга | Гүйцэтгэх захирал |
| Компанийн хаяг: | Өмнөговь аймаг Ханхонгор сум мандах баг<br>Харилцах утас:881№3389 11345959 .91935355 96658704 | |
| Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар: | | |
| Регистрийн дугаар: | 2016273 | |
| Бүртгэгдсэн он сар | 2006он | |
| Үйл ажиллагааны чиглэл | Аялал жуулчлал | |
| Санхүү | П.Мөнгөнцэцэг | Ерөнхий санхүүч |
| Ажилчдын тоо | | |
| Аудитын компани | "Ай Жэй Эй Эйч -Аудит" ХХК<br>Нягтлан бодох бүртгэл, татвар, санхүүгийн хяналт баталгаажуулалтын итгэмжлэгдсэн хөндлөнгийн байгууллага | |
| Аудитын компанийн хаяг | Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 14-р хороо, Борх төв 310,311 тоот<br>Утас: 976-11450279, Факс: 976-11-450279. | |

**2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл**

Энэхүү тайланд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын үүрэгтэй хамт уншигдах дараах мэдэгдэл нь "Жуулчин говь"ХК-ний 2018 оны 12-р сарын 31-ны өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг ялгах үүднээс хийгдсэн болно.

Удирдлага нь компанийн санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй бөгөөд эдгээр санхүүгийн тайлангууд нь 2018 оны 12-р сарын 31-нээрх санхүүгийн байдал, тайлант жилийн санхүүгийн гүйцэтгэл, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийг СТОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байх ёстой.

Санхүүгийн тайлан бэлтгэхэд удирдлага нь дараах зүйлсэд хариуцлага хүлээдэг. Үүнд:

- ✓ Тохиромжтой нягтлан бодох бүртгэлийн бодлого сонгож, тууштай мөрдөх
- ✓ Үндэслэлтэй, хянамгай шийдэл гаргах болон тооцоолол хийх
- ✓ СТОУС-ыг дагаж мөрдсөн эсэхээ дурдаж, хэрэв материаллаг ялгаа буюу өөрчлөлт байгаа бол санхүүгийн тайланд тодруулж, тайлбарлах
- ✓ Компани ойрын ирээдүйд бизнесээ үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл нь тохиромжгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайланг үйл ажиллагааны суурийг үндэслэж бэлтгэх

Удирдлага нь түүнчлэн,

- ✓ Дотоод хяналтын үр дүнтэй, тууштай систем боловсруулж, хэрэгжүүлж ажиллуулах
- ✓ Компанийн санхүүгийн байдлыг аливаа хугацаанд үнэн зөвөөр харуулахуйц нягтлан бодох бүртгэл хөтлөх
- ✓ Компанийн нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхүйцээр зохион байгуулагдсан байх
- ✓ Хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх
- ✓ Залилан мэхний асуудал, алдаа болон бусад зөрчлийг илрүүлэх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх зэрэг үүрэг хүлээдэг.

Бид эдгээр үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн

Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

"Жуулчин говь" ХК-ийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөр дууссан болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

Гүйцэтгэх захирал                Нягтлан бодогч

**" Жуулчин говь" ХК-ийн захирал Б.Гантулга**

## Хараат бус аудиторын дүгнэлт

"Жуулчин говь" ХК-ний 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөрх үлдэгдлийн тэнцэл, тухайн өдрөөр тасалбар болсон хугацааны орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, бусад тайлбар тэмдэглэлээс бүрдэх санхүүгийн тайланд аудит хийлээ.

**Санхүүгийн тайлангийн талаархи компанийн удирдлагын хариуцлага**

Эдгээр санхүүгийн тайланг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Залилан ажиллагаа буюу алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайланг бэлтгэж, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх мөрдөх, нягтлан бодох бүртгэлийн зохих бодлогыг сонгож, хэрэглэх; тухайн нөхцөл байдалд үндэслэлтэй нягтлан бодох бүртгэлийн тооцоолдыг хийх нь энэхүү хариуцлагад хамаарна.

**Санхүүгийн тайланг-ийн талаархи аудиторын хариуцлага**

Бидний хариуцлага бол хийсэн аудитаа үндэслэн эдгээр санхүүгийн тайланд дүгнэлт гаргах явдал билээ. Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандартын дагуу явуулсан. Эдгээр стандартууд нь санхүүгийн тайлан материаллаг алдаагүй гэсэн ул үндэслэлтэй нотолгоог олж авах байдлаар аудитыг төлөвлөж, гүйцэтгэх ба ёс зүйн шаардлагуудыг мөрдөхийг биднээс шаардлаг.

Аудит нь санхүүгийн тайлан дахь дүн ба тодруулгын талаархи үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд гүйцэтгэх горимуудыг багтаадаг.Сонгох горим нь аудиторын үнэлгээ дүгнэлт үүнд дотроо залилан ажиллагаа ба алдааны улмаас санхүүгийн тайлан материаллагаар буруу илэрхийлэгдэх эрсдлийн үнэлгээнээс хамаардаг. Эдгээр эрсдлийн үнэлгээг хийхдээ аудитор нь компанийн дотоод хяналтын үр дүнтэй байдлын талаар дүгнэлт гаргах зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирсон аудитын горимыг төлөвлөхийн тулд компанийн санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулахтай холбогдсон дотоод хяналтыг авч үзсэн. Аудит нь удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолдын үндэслэлтэй байдал, ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын зохистой байдлын үнэлгээ, түүнчлэн санхүүгийн тайлангийн ерөнхий тайлагналын үнэлгээг багтаадаг.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах үндэслэлийг бүрдүүлэхэд хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

Дүгнэлт

Бидний аудитлагдсан санхүүгийн тайлан нь **"Жуулчин говь."**ХК- ийн 2018 оны 12-р сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна.

## Тайлангийн хэрэглээ

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 5-р зүйлд заасан хуулийн этгээд болох "Жуулчин говь" ХК-ийн хувьцаа эзэмшигч болон хөрөнгө оруулагчдад зориулж бэлтгэсэн.

ЗАХИРАЛ Г.ЭНХМАА